

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН ТОЙМ

2015 оны 6 дугаар сар



- Эдийн засгийн бодит өсөлт 2015 оны эхний улиралд 4.4 хувь болж саарав.
- Оны эхний 4 сард төлбөрийн тэнцлийн алдагдал 320 сая ам.долларт хүрлээ.
- Эхний 4 сард гадаадын шууд хөрөнгө оруулалтын данс 71 сая ам.долларын цэвэр гарах урсгалтай байв.
- Өнгөрсөн 5 дугаар сард Оюутолгойн 2 дахь шатны хөрөнгийн оруулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд 2 тал гарын үсэг зурсантай холбоотойгоор сүүлийн хэдэн 7 хоногт зах зээлийн орчин мэдэгдэхүйц сайжрав.
- Төсвийн орлогын тасалдал оны эхний 5 сарын байдлаар 18 хувьтай байгаа нь төсөвт тодотгол хийж төсөвт итгэх итгэлийг хангах шаардлага тулгарч байна.

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн сүүлийн үеийн өрнөл

Өмнөх оны эцэст жилийн 8 хувьтай гарч байсан эдийн засгийн өсөлт 2015 оны эхний улиралд 4.4 хувьд болж буураад байна. Гадаадын хөрөнгө оруулалт үргэлжлэн буурч буй орчинд эдийн засаг дахь нийт хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.6 хувиар огцом агшаад байна. Нийт хэрэглээ сул байгаа буюу 2014 оны сүүлийн улиралд жилийн 2.4 хувиар, энэ оны эхний улиралд 2.7 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Нэг талдаа импорт буурч байгаа, нөгөө талдаа уул, уурхайн бүтээгдэхүүнээс хамаарч экспорт харьцангуй өндөр өсөлттэй байгаа нь худалдааны тэнцэл сайжрахад нөлөөлж байгаа ч эдийн засгийн идэвхжил сул байгааг мөн илтгэж байна.

2014 оны эцсийн улиралд 20.5 хувиар өссөн уул, уурхайн салбарын ДНБ энэ оны 1 дүгээр улиралд 13.8 болж саарав. Зэс, алт болон газрын тосны үйлдвэрлэлийн өсөлт буурч байгаа нь уул, уурхайн салбарын өсөлт саарахад голлон нөлөөлөв. Өнгөрөгч 1 дүгээр улиралд жилийн 13 хувийн өсөлттэй байсан зэсийн үйлдвэрлэл 4 болон 5 дугаар сард 13.6 хувиар өсөв. Харин нүүрсний үйлдвэрлэл эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурав. Зэсийн үйлдвэрлэл эхний 5 сард жилийн 19.4 хувиар өсчээ.

Уул, уурхайн бус салбарын ДНБ эхний улиралд 1.5 хувийн өсөлттэй гарч өмнөх улирлын 4.1 хувийн өсөлтөөс буурлаа. Бөөний болон жижиглэн худалдааны салбар болон бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ харгалзан 7.6 хувь, 14.8 хувиар тус тус буурсан нь импорт нэлээд буурч байгааг илтгэж байна. Аж, үйлдвэрийн салбар жилийн 11.1 хувиар өссөн нь голчлон нэхмэлийн аж үйлдвэрийн өндөр өсөлтөөс шалтгаалав. ХАА-н салбарын өсөлт 9.2 хувьтай байгаа бөгөөд барилгын салбар 31.8 хувийн өсөлт үзүүлсэн нь орон сууны барилга, томоохон худалдааны төвүүд ашиглалтад орсонтой холбон тайлбарлахаар байна.

Ажлын байрны төрлөөс харахад хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил суларч байгааг илтгэж байна. Эдийн засгийн идэвхжил саарч буй орчинд 2014 оны эхний улиралд ажилгүйдлийн түвшин 9.4% байсан бол энэ оны эхний улиралд буурч гарав. Албан бус ажлын байр буюу хувиараа аж, ахуй эрхлэгч, гэр бүлийн бизнес, мал, аж ахуйн бизнесүүд нь оффисийн шинжтэй ажлын байртай харьцуулахад ажиллах хүчнийг ихээр шингээсэн байна. Энэ нь ажлын байрны чанар суларч байгааг илтгэж байна. Албан бус ажлын байрны тоо эхний улирлын байдлаар нийт ажлын байрны 49.8 хувийг бүрдүүлж


Энэхүү сарын тоймыг Дэлхийн банкны Макро эдийн засаг, төсвийн бодлогын газрын хэлтсийн захирал ноён Матью Вергис, тэргүүлэх эдийн засагч хатагтай Чорчин Го нарын удирлаган доор Монголын суурин төлөөлөгчийн газрын эдийн засагчид болох ахлах эдийн засагч ноён Тайхюн Ли, эдийн засагч хатагтай Ш.Алтанцэцэг болон эдийн засагч ноён Б.Даваадалай нар бэлтгэв.

байгаа бөгөөд энэ үзүүлэлт өмнөх оны мөн үед 49.3 хувь, 2013 онд 46.3 хувьтай байв.

Инфляци 5 дугаар сард үргэлжлэн буурав. УБ хотын хэмжээнд тооцсон инфляци 5 дугаар сарын эцэст 7.5 хувь болж өмнөх 1, 2 дугаар

сарын 8.8 хувийн өсөлтөөс буурав. Улсын инфляци 8 хувьтай гарсан нь мөн өмнөх сарын 9.2 хувийн өсөлтөөс саарлаа. Суурь инфляцийн түвшин 10 хувь болж 4 дүгээр сарын эцсийн 11 хувиас буурав.


Зураг 1. Эдийн засгийн өсөлт эхний улиралд 4.4% болж саарсан нь уул, уурхай болон бусад салбарын өсөлт буурсанаас шалтгаалав.



Эх үүсвэр: УСХ, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 2. Инфляци 5 дугаар сарын эцэст 7.5% болж буурсан ч хүнсний барааны 3 дугаар сараас хойш хурдтай өсч байна.

Хүнс болон бусад бараа, үйлчилгээний инфляци (УБ хотын инфляци, жилийн өсөлт, %)




Худалдааны тэнцлийн ашиг буурч байгаатай холбоотойгоор өнгөрөгч 4 дүгээр сард урсгал тэнцлийн алдагдал бага зэрэг нэмэгдэж 80.4 тэрбум ам.долларт хүрлээ. Урсгал тэнцэл 1 дүгээр сард 86.9 сая ам.долларын ашигтай гарсанаас хойш 2-оос 4 дүгээр сард нийт 210.8 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Экспорт 3 хувиар буурсан, импорт 32.1 хувиар буурсанаас шалтгаалан худалдааны тэнцэл оны эхний 5 сарын байдлаар 422.3 сая ам.долларын ашигтай гарав. Гэвч сараар нь харвал худалдааны тэнцлийн ашиг үргэлжлэн буурч байгааг харж болно. Тухайлбал, худалдааны тэнцлийн ашиг 1 дүгээр сард 225 сая ам.доллар байсан бол 5 дугаар сард 4.3 сая ам.доллар болж буугаад байна. Уул, уурхайн бүтээгдэхүүний экспорттой холбоотойгоор экспортын хэмжээ 5 дугаар сард жилийн 15.8 хувиар буураад байна. Нүүрсний экспортын биет хэмжээ 5 дугаар сарын байдлаар 49 хувийн бууралттай байгаа нь түүний нийт экспортын үнийн дүнг 46 хувиар буурахад нөлөөллөө. Харин 4 дүгээр сард 14 хувиар агшиж байсан зэсийн экспорт 5 дугаар сард 17 хувийн өсөлтийг үзүүлэв. Газрын тосны үнэ бага байгаагаас шалтгаалан газрын тосны экспорт 27 хувиар буурчээ. Нийт импорт 5 дугаар сарын эцсийн байдлаар 32

хувийн бууралттай байгаа нь эдийн засгийн дотоод эрэлт саарч байгааг илтгэж байна. Хөрөнгө оруулалтын шинжтэй импортын бараа жилийн 28 хувиар, хэрэглээний барааны импорт 33 хувиар тус тус буурчээ. Бензин, шатахууны импорт оны эхний 5 сард жилийн 39 хувиар буурсан бол бусад барааны импорт 30 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Зураг 3. Экспортын өсөлт саарч байгаатай уялдан урсгал тэнцэл муудаж байна.

Экспорт, импортын өсөлт (3 сарын шаталсан дундаж) болон урсгал тэнцэл (3 сарын нийлбэрээр тооцсон)



Эх үүсвэр: Монголбанкны тоо, мэдээлэл, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо


Хөрөнгө, санхүүгийн тэнцлийн мэдээнээс үзэхэд оны эхний 4 сард 125.7 сая ам.долларын цэвэр гадагшлах урсгалтай байна. Жилийн өмнө 332 сая ам.долларын цэвэр орох урсгалтай байсан ГШХО оны эхний 4 сард 71 сая ам.долларын цэвэр ГШХО-ын гадагшлах урсгалтай гарчээ. Компани хоорондын өглөгийн буцаан төлөлт нь дээрх ГШХО-ын гадагшлах урсгалд голлох нөлөөг үзүүлжээ. Гэвч 4 дүгээр сард 38 сая ам.долларын ГШХО-ын цэвэр дотогшлох урсгал бүртгэгдсэн байна. Харин 455 сая ам.долларын санхүүгийн цэвэр дотогшлох урсгал оны эхний 4 сард бэлэн мөнгө, харилцахын дансаар орж ирсэн байгааг Төвбанкны своп хэлцэлтэй холбон тайлбарлахаар байна.

Төлбөрийн тэнцлийн алдагдал оны эхний 4 сард 320 сая ам.долларт хүрсэн бөгөөд зөвхөн 4 дүгээр сард 49 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Төвбанкны Хятадын ардын банкны хийж төгрөг-юаны своп хэлцэл нь ГВАН дээр ирж буй дарамтыг зөөллөх нөлөөг үзүүлжээ.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалж ГВАН өнгөрөгч 4 дүгээр сард буурсан ч гадаад зээллэгийн нөлөөгөөр 5 дугаар сард ГВАН бага зэрэг өсөв. ГВАН 4 дүгээр сарын эцэст 1,267 сая ам.доллар болж оны эцсээс 382 сая ам.доллараар буурчээ. Харин 5 дугаар сард 1,590 сая ам.доллар болж өссөн нь Худалдаа

Зураг 4. Уул, уурхайн бүтээгдэхүүний экспорт саарч байгаа болон дотоод эрэлт хумигдаж байгаа импорт өнгөрөгч 4 дүгээр сард буурахад голлон нөлөөлөв.

Гол экспорт, импортын гол нэрийн бүтээгдэхүүний жилийн өсөлт (3 сарын нийлбэрээр тооцсон, %)



хөгжлийн банкны гадаад зээллэгтэй холбоотой байв. Мөн Худалдаа, хөгжлийн банк 5 дугаар сард Засгийн газрын баталгаатай 500 сая ам.долларын бондыг гадаад зах дээр 9.375 хувийн хүүтэй гаргасан. Урт хугацааны своп хэлцэлээр ХХБ үг бондын ам.долларыг Төвбанкнд худалдаад байна.


Төгрөгийн ханшийн үргэлжлэн суларч буй хандлага харин 4 дүгээр сарын дундаас саарав. Төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй орчинд эхний 4 сард төгрөгийн ханш 3.8 хувиар суларсан бол сүүлийн 2 сард 6 хувиар ам.долларын эсрэг чангараад байна. Оны эцэст нэг ам.доллар 1989 төгрөгтэй тэнцэж байсан бол 6 дугаар сарын 13-ны байдлаар 1862 төгрөгтэй тэнцээд байна. Уг төгрөгийн ханшийн чангаралт нь өнгөрөгч 5 дугаар сард зурагдсан Оюутолгойн 2 дугаар шатны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнөөс голчлон шатгаалав. Харин 6 дугаар сарын 16-наас төгрөгийн ханш дахин суларч эхлэв.

Өнгөрөгч 5 дугаар сарын 18-нд Оюутолгойн 2 дугаар шатны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд 2 тал гарын үсэг зурагдлаа. Уг баримт бичиг нь хөрөнгө оруулагчдын татвар болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон удирдлагын зардалын асуудлууд дээр зөвшилцөлд хүрсэн. Төслийн шаардлагатай тооцоонууд дуусч ажил эхэлмэгц 4 тэрбум ам.долларын төслийн санхүүжилт орж ирэхээр байгаа нь ирэх

жилүүдэд ГШХО-д ихээхэн нөлөө үзүүлэхээр байна.

Зураг 5. Төгрөг-юаны своп хэлцэл хийгдэж байгаа ч ГШХО буурч байгаагаас төлбөрийн тэнцэл эхний 4 сард өндөр алдагдалтай хэвээр байна.

Хөрөнгийн цэвэр урсгал болон Төлбөрийн тэнцэл (сая ам.доллараар, 3 сарын шаталсан дундаж)



Эх үүсвэр: Монголбанкны тоо, мэдээлэл, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Чанаргүй зээлийн хэмжээ 4 болон 5 дугаар сард үргэлжлэн өсч түүний нийт зээлд эзлэх хувь 4 хувиас даваад байна. Дампуурсан банкуудыг хасч тооцсон чанаргүй зээлийн хэмжээ өнгөрөгч 5 дугаар сард нийт зээлийн 4.2 хувьд хүрч өмнөх 3 дугаар сарын 3.9 хувь, оны эцэс дэхь 3.1 хувиас тус тус өсөөд байна. Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 5 дугаар сард нийт зээлийн 5 хувьтай тэнцэж, өмнөх сарын 4.9 хувь болон оны эцсийн 2.2 хувиас тус тус өсөөд байна.

Гадаад валютаарх зээл буурсан, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээл саарч байгаа болон банкин дахь хадгаламж буурч байгаагаас шалтгаалан өнгөрөгч 4 дүгээр сард банкны системийн эх үүсвэр (tight liquidity) сүл байв. Банкны системийн зээлийн өсөлт (үнэт цаасжуулсан орон сууцны зээлийг оруулж тооцсон) 5 дугаар сард жилийн 8.4 хувьд хүрч өмнөх сарын 12 хувь, онц эцсийн 20 хувиас үргэлжлэн буураад байна. Импорт буурч байгаа болон эрсдэлтэй зээлдэгч дээр эрсдлийн хувийг нэмэгдүүлсэн зэргээс гадаад валютын зээл 5 дугаар сард мөн буурчээ. 3 дугаар сард 20.6 хувийн өсөлттэй байсан төгрөгийн зээл 5 дугаар сарын эцэст 16 хувь болж буурсан нь эдийн засгийн идэвхжил саарч байгаа болон үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлүүд хумигдаж байгаагаар голлон

Зураг 6. 2 сарын хугацаанд төгрөг ам.долларын эсрэг чангарсаны дараа 6 дугаар сарын дундаас төгрөгийн дахин суларч эхэллээ.

Төгрөгийн ханш, өдрөөр




тайлбарлагдахаар байна. Банкны эх үүсвэрийн өсөлт мөн саарч байна. Банкны хадгаламж 5 дугаар сард жилийн өмнөхөөс 3.3 хувиар буураад байна. M2 мөнгөний жилийн өсөлт -3.8 хувь болсон нь зээл хумигдаж байгаа болон гадаад цэвэр активын бууралтыг илтгэж байна.

Төвбанкны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн хэмжээгээ бууруулж байгаа ч орон сууцны зээл өссөөр байна. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн хэмжээ 5 дугаар сарын эцэст 0.7 их наяд төгрөг болж буураад байна. Орон сууцны зээлийн үлдэгдэл 5 дугаар сарын эцэст 2.3 их наяд төгрөг болж, оны эхний 5 сард 13.7 хувиар өсчээ. МИК 1.23 их наяд төгрөгийн орон сууцны зээл үнэт цаасжуулаад байгаа бөгөөд үүний 90 хувийг Төвбанк худалдан авч байгаа юм. Харин Төвбанкны банкуудаас авах авлага 5 дугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж оны эцсийн 2.6 их наядтай харьцуулахад нэлээд буурчээ. Энэ нь үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээл саарч байгаа болон Төвбанкны МИК-ийн орон сууцны зээлийн бондын худалдан авалттай холбон тайлбарлахаар байна. Төвбанкны санхүүгийн бус сектор (МИК-ийг оруулсан)-оос авах авлага 2.1 их наяд төгрөг болж оны эцсийн 1.7 их наядаас өсөөд байгааг МИК-ийн

бондын худалдан авалттай холбон тайлбарлахаар байна.

Зураг 7. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 4.2 хувьд хүрээд байна.

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ болон НЗӨУ-д эзлэх хувь (тэрбум төгрөг, %)




Эх үүсвэр: Монголбанкны тоо, мэдээлэл, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Төсвийн орлогын тасалдал нь төсвийн төлөвлөлтийн итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, тохиргоо хийгдэх шаардлагатайг сануулав.

Оны эхний 5 сарын байдлаар орлогын тасалдал 18 хувьтай байна. Татварын орлого 11 хувиар тасалдсан нь голчлон гадаад худалдааны татварын орлогын бууралтаас хамаарчээ. Төсвийн зарлагын гүйцэтгэл 70 хувьтай байна. Цалин, нийгмийн халамжийн зардалын гүйцэтгэл 90 хувьтай байгаа бөгөөд бусад байнгын бус шинжтэй (discretionary spending) зардалын гүйцэтгэл тун тааруу байгаа ба ялангуяа хөрөнгийн зардалын гүйцэтгэл дөнгөж 30 хувьтай байна. Өнгөрөгч

Зураг 9. Төсвийн орлогын тасалдал 5 дугаар сар үргэлжлэн өссөн бөгөөд төсвийн зардал хатуу хэвээр байна.


Орлого, зардалын өсөлт (оны эхнээс тооцсон нийлбэрээр тооцов, %)



Эх үүсвэр: Монголбанк, Сангийн яамны тоо, мэдээлэл, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Зураг 8. Банкны зээлийн өсөлт 5 дугаар сард үргэлжлэн саарсан бөгөөд хадгаламжийн өсөлт сөрөг түвшинд байна.


Банкны зээл, хадгаламжийн жилийн өсөлт болон нөөц хадгаламжийн харьцаа (%)



5 дугаар сарын 18-нд 2016-19 оны төсвийн дунд хүрээний мэдэгдэл УИХ-аар батлагдсан бөгөөд Сангийн яамны тооцоогоор энэ жил орлогын тасалдал 498 тэрбум төгрөгт хүрэхээр байна (7 хувь). Банкны системд эх үүсвэрийн дутагдалтай орчинд Засгийн газрын үнэт цаасны хүү жилийн 15 хувьтай хэвээр байна. Болзошгүй өр төлбөр (payment arrears)-өөс урьдчилан сэргийлэх үүднээс Сангийн яамнаас төсвийн шат бүрийн захирагчдад зарлагаа бодитой тооцож, эрэмблэхийг зөвлөж байна. Орлогын тасалдалтай орчинд Засгийн гарар төсвөө тодотгох асуудлыг ярьж байна.

Зураг 10. 2014 оны сүүлээс өссөн Засгийн газрын бондын зардал эхний 5 сард өндөр хэвээр байна.

Засгийн газрын үнэт цаасны хүү болон бусад мөнгөний захын хүүгийн түвшин (%)



САРЫН ОНЦЛОХ СЭДЭВ

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ): 2016-18 онуудын төсвийн бодлогын төлөв

2016-18 оны ДХТХМ өнгөрөгч 5 дугаар сарын 21-нд УИХ-аар батлагдлаа. Энэ удаагийн ДХТХМ нь өмнөх жилийн 2015-18 оны ДХТХМ-ийн орлогын төсөөллийг шинэчилж, төсвийн тогтвортой байдлын хуулийн заалтыг хангахын тулд төсвийн зарлага тал дээр ямар өөрчлөлт хийх талаар тусгажээ.

Төсвийн орлогын тасалдал нэмэгдэж байгаагаас цаашид ЗГ зардалаа танах шаардлага бий болж байна. ДХТХМ-д дурдсанаар оны эцэст орлогын тасалдал 498 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Импорт бүүрч байгаа, зэс, газрын тосны үнэ буурсан болон эдийн засгийн идэвхжил саарч байгаа нь дээрх хэмжээний төсвийн орлогын тасалдлыг бий болгохоор байна. ТТБХ-ийн шаардлагыг хангахын тулд төсвийн зардлыг дээрх орлогын тасалдлын хэмжээгээр танах шаардлага тулгарах эрсдэлтэй байна.

Дээрх төсвийн төлөвлөлт нь орлогын төсөөллийг бодитой тооцох талаар илүүтэй онцлов. Уг баримт бичигт дурдсанаар өнгөрсөн жилүүдэд төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж байсан нь төсвийн бодлогод итгэх итгэлд сөргөөр нөлөөлсөнийг онцолжээ. ДХТХМ-д 2016-18 онд эдийн өсөлтийг дундажаар 5 хувь байхаар төсөөлсөн бөгөөд энэ голчлон гадаад эдийн засгийн орчин болон төсвийн орлогын төсөөлөл буурсанаас голлон шалтгаалав. Төсвийн орлогын төсөөллийг өмнөх жилийн ДХТХМ-ээс 2015 7.4 хувиар, 2016 онд 3.4 хувиар, 2017 онд 4.3 хувиар тус тус бууруулжээ.

ДХТХМ-д ТТБХуулийн шаардлагыг хангахын тулд төсвийн алдагдлыг 2016 онд ДНБ-ий 4 хувьд, 2017 онд 3 хувьд, 2018 онд 2 хувьд барихаар тооцжээ. Уг мэдэгдэлд хэрэв яамдуудаас ирсэн бүх зардлыг төсөвт тусгавал төсвийн алдагдал энэ онд 19 хувь хүрэх боломжтой байсан гэдгийг онцолжээ. Төсвийн зардлын өсөлтийг 2016 онд 5 хувьд

2017-18 онуудад 2 хувиас ихгүй байхаар тооцжээ. 2016 онд төсвийн алдагдлыг 4 хувьд барихад дараах арга хэмжээнүүдийг авахаар төлөвлөжээ. Үүнд:

- Байнгын бус шинжтэй (discretionary recurrent spending) урсгал зардлыг бууруулах, ЗГ-ийн үнэт цаас гаргах хэмжээгээ бууруулах замаар хүүгийн зардалаа багасгах.
- Зөвхөн хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төслүүдийг үргэлжлүүлэх, Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтын хэмжээг 200 тэрбум төгрөгт барих. Гадаад зээлийг ач холбогдлоор эрэмблэх замаар гадаад зээлийн ашиглалтаа багасгах.


ДХТХМ-ийг сайн хэрэгжүүлэх нь цаашид төсвийн бодлогод хийгдэх тохиргоо үр дүнтэй хийгдэнэ гэсэн итгэлийг нэмэгдүүлнэ. 2015 оны төсөвт тодотгол хийж ДХТХМ-д тооцсон орлогын төсөөллийг хэрэгжүүлэх шаардлагатай. 2016 оны төсөвт тодорхой тохиргоо хийж чадвал дараагийн онуудад төсвийн бодлогод өөрчлөлт гарна гэсэн итгэлийг нэмэгдүүлэх билээ. УИХ дээр төсөв хэлэлцэж буй явцад төсвийн орлогыг үндэслэлгүй нэмэгдүүлдэг байдлаас аль болох зайлсхийх нь байна.

Дараагийн ДХТХМ-д төсвийн зардалыг ач холбогдлоор ангилах, төсвийн бодлогод шаардлагатай илүү шинэчлэлийн шинжтэй арга хэмжээний талаар дурдах нь уг баримт бичигт итгэх итгэлийг сайжруулах юм. Энэ удаагийн ДХТХМ-д орлогын төсөөллийг өмнөх жилүүдээс илүү бодитой төсөөлсөн боловч зөвхөн нэг жилийн төсвийн төлөвлөлтөд анхаардаг байдал хэвээр хадгалагдсаар байна. Өөрөөр хэлбэл, дунд хугацааны төсвийн төлөвлөлтөд (орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлаа ач холбогдлоор нь ангилан илүү үр ашгийг нь

нэмэгдүүлэх) анхаарах тал дээр дутагдалтай байна.


Зураг 11. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ) нь илүү бодитой төлөвлөлт дээр үндэслэж орлогын төсөөллийг бууруулжээ...

Орлогын төсөөлөл (их наяд төгрөг): 2016-18 оны ДХТХМ болон 2015-17 оны ДХТХМ



Зураг 12. ... Төсвийн тогтвортой байдлын хуулийн заалттай нийцтэй байхын тулд төсвийн зардалыг бууруулахаар төсөөлжээ.

Төсвийн зардал (их наяд төгрөг): 2016-18 оны ДХТХМ болон 2015-17 оны ДХТХМ



Эх үүсвэр: Сангийн яамны тоо, мэдээлэл, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо